

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны
 2023 оны 03 сарын 07 өдрийн
 24... албан бичгийн хавсралт

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ 2023 ОНЫ 3 ДУГААР САРЫН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2023 оны 3 дугаар сарын 24-ний өдөр

№	Хийгдэх ажил	Хүрэх үр дүн	Хугацаа	Биелэлт
1	Хугацаатай мэдээ, тайлан гаргах	Төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг	дараа сарын 02-ны дотор	Тайлант хугацаанд манай байгууллагад 46.007,0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 34.938,3 мянган төгрөгийг зарцуулж 11.068,7 мянган төгрөг хэмнэсэн.
		Шилэн дансны мэдээллийг нэгдсэн цахим санд оруулах	Дараа сарын 08-ны дотор	Тайлант хугацаанд оруулбал зохих 13 мэдээллийг хуулийн хугацаанд нь оруулсан.
		Нийгмийн даатгалын тайлан гаргаж, хүргүүлэх	Дараа сарын 05-ны дотор	2-р сарын НДШ-ийн тайланг хуулийн хугацаанд илгээж, тайлагнасан.
2	Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 2-р цэцэрлэгийн 2022-2023 оны үйл ажиллагаанд дотоод аудит хийх	Байгууллагын үйл ажиллагаа сайжирна	3 сард	Сүмбэр сумын 2-р цэцэрлэгийн 2022-2023 оны үйл ажиллагаанд дотоод аудит хийж байна. Шалгалтын явц 90 хувьтай байна.
3	Говьсүмбэр аймгийн Баянтал сумын ЗДТГазрын 2020-2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх	Санхүүгийн сахилга бат сайжирна	3 сард	Баянтал сумын ЗДТГазрын 2020-2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж байна. Шалгалтын явц 50 хувьтай байна.
4	Авлигатай тэмцэх газартай хамтран хяналт, шалгалт хийх	Санхүүгийн сахилга бат сайжирна	3 сард	Баянтал сумын 4-р цэцэрлэгийн 2018-2021 оны санхүүгийн баримтад АТГ-н төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж 18,971.3 мянган төгрөгийн зөрчил илрүүлж хуулийн байгууллагад шилжүүлсэн.

5	Аймгийн Прокурорын газартай хамтран ШШГ Хорих 425-р ангид ял эдэлж байгаа иргэдийн цалин хөлсөнд хяналт, шалгалт хийх	Хугацаанд нь хүргүүлсэн байна.	3 сард	ШШГГазар-425 нээлттэй хорих ангид хоригдож байгаа хоригдлуудын 2022 оны цалин хөлсөнд төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийлээ. Шалгалтаар нийт 1,352.0 мянган төгрөгийн зөрчил илэрч нийт 552.0 мянган төгрөгийн нөхөн төлбөрийн акт. Үүнээс: 440.0 мянган төгрөгийг нөхөн олгуулах 112.0 мянган төгрөгийг орон нутгийн орлого болгох Мөн 800.0 мянган төгрөгийн хугацаатай албан шаардлага хүргүүлэв.
6	Шивээговь сумын 3-р цэцэрлэгийн 2022-2023 оны үйл ажиллагаанд дотоод аудит хийх	Байгууллагын үйл ажиллагаа сайжирна	3 сард	Шивээговь сумын 3-р цэцэрлэгийн 2022-2023 оны үйл ажиллагаанд дотоод аудит хийхээр удирдамж хүргүүлсэн байна.
7	Сүмбэр сумын ЗДТГ-ын 2022- 2023 оны үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалт хийх	Санхүүгийн сахилга бат сайжирна	3 сард	Сүмбэр сумын ЗДТГ-ын 2022-2023 оны үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалт хийхээр удирдамж хүргүүлсэн байна.
8	Шивээговь сумын ЗДТГ-ын 2022- 2023 оны үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалт хийх	Санхүүгийн сахилга бат сайжирна	3 сард	Шивээговь сумын ЗДТГ-ын 2022-2023 оны үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалт хийхээр удирдамж хүргүүлсэн байна.
9	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангуулах	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангагдах	3 сард	Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасны дагуу аймгийн төсөвт, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нийт 43 байгууллагын шилэн дансны мэдээллийг цахим хуудсанд үнэн зөв болон цаг хугацаандаа оруулж байгаа эсэхэд хяналт тавьж ажилладаг. 1,2 дугаар сарын шилэн дансны мэдээ оруулалтын байдал 95.4 хувьтай байна. Энэ нь өмнөх сараас 9.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна.
10	Мэдээллийн ил тод байдлыг хангах	Мэдээллийн ил тод байдал хангагдах	3 сард	Мэдээллийн ил тод байдлыг хангаж, байгууллагын үйл ажиллагааг иргэдэд ойлгомжтой байлгах үүднээс байгууллагын веб хуудас болон самбарт 5 мэдээ байршуулсан.

11	Бусад ажил	Байгууллагын үйл ажиллагаа сайжирна.	3 сард	Аймгийн удирдах ажилтны шуурхай зөвлөгөөний 2 удаагийн хурлаас өгсөн 8 үүрэг даалгаврын биелэлтийг хугацаанд нь хүргүүлсэн.
				Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулагддаг "7:4:10" вебинар сургалтад албан хаагчид бүрэн хамрагдсан.
				2023 оны 2 дугаар сарын 28-ны өдөр зохион байгуулсан Аймгийн Засаг Даргын Тамгын газраас зохион байгуулсан сургалтад дотоод аудитор Г.Насанжаргал хамрагдсан.
				2023 оны 03 дүгээр сарын 16,17-ны өдөр Сангийн яамнаас зохион байгуулсан "Санхүүгийн хяналт, дотоод аудитын ажилтны сургалт-2023" сургалтад 4 албан хаагчийг хамруулсан.
				2023 оны 03 дугаар сарын 22,23-ны өдрүүдэд Орон нутаг дахь төрийн албан хаагчдад зориулсан "Алсын хараа-2050", Монгол Улсын урт хугацааны бодлого, түүний эхний үе шат "Шинэ сэргэлтийн бодлого"-ын сургагч багш бэлтгэх богино хугацааны сургалтад 2 албан хаагч хамрагдлаа.
				2023 оны 3 дугаар сарын 15-ны өдөр байгууллагын ойр ойрчмын 50м газрын цэвэрлэгээг хийж, байгууллагын веб хуудас, фэйсбүүк хуудас, Хоггүй Сүмбэр-т тус тус мэдээлэл байршуулсан.
				Төрийн бусад байгууллагаас зохион байгуулсан арга хэмжээг дэмжиж оролцсон. Үүнд: -Сүмбэр сумын ЗДТГ-аас 3 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулсан "Нээлттэй хаалганы өдөрлөг" албан хаагчид оролцож төрийн үйлчилгээ авсан. -Эрүүл мэндийн газраас 3 дугаар сарын 20-ны өдөр зохион байгуулсан "ЭНЭ ЖИЛДЭЭ-ЭРҮҮЛ ЖИНДЭЭ" арга хэмжээний нээлтэд бүх албан хаагчид оролцсон.

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:

Дотоод аудитор:



Л.Эрдэнэчимэг